

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Д\Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	Үүрэг, даалгавар-НЭГ: 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, хяналт тавьж ажиллах, Худалдан авах ажиллагааг эрчимжүүлж ажиллах, Зураг төсөв, ажлын даалгаваргүй ажлуудаа эрчимжүүлэх, Газар чөлөөлөх ажлыг эрчимжүүлэх Худалдан авах ажиллагааны цахим системд хугацаанд тайлagnаж, ажлаа эрчимжүүлэх			
1.	<p>- Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Улс, Нийслэл, Дүүрэг, Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Бэлтгэл ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 45 - Тендерийн шатандаа байгаа төсөл арга хэмжээ – 45 - Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 66 - Ажил 100 хувь хийгдэж дууссан – 14 <p>Нийт хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн мэдээг 14 хоног тутамд шинэчлэн ажиллаж байна.</p> <p>- 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ДОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжих орон сууцны дээвэр засвар-1, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх талбай тохижуулах, засварлах-1, хүүхдийн тоглоомын талбай тохижуулах, засварлах-1, автобусны буудлын тохижилт-1, гудамж сайжруулах-11, нийт 15 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төсвийг гаргуулан дүүргийн Худалдан авах ажиллагааны албандаа хүргүүлсэн.</p> <p>- 2022 оны төлөвлөгөөнд 40 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 1 дүгээр улиралд 22 төсөл арга хэмжээний тендерийг цахимаар зохион байгуулан үр дүнг тухай бүрт системд нийтэлсэн. Цаашид зохион байгуулах тендер шалгаруулалтыг 100 хувиар цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан зохион байгуулж, үр дүн, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэн ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>- Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, бүтээн байгуулалтын ажлыг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх үүднээс газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх ажлын хүрээнд 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 17 дугаар хороодод</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50

	баригдах бүтээн байгуулалтын ажлын газар чөлөөлөлтийн нөлөөлөлд нөхөх олговортойгоор чөлөөлөх нийт 265 нэгж талбараас 162 нэгж талбарыг бүрэн чөлөөлж, 103 нэгж талбарын газрыг чөлөөлөхөөр нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран ажиллаж байна.		
--	---	--	--

Үүрэг, даалгавар ХОЁР: Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.

2.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжаар Дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гарцаашийн газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр 39 дүгээр цэцэрлэгийн урд тал, хойд талд зөвшөөрөлгүй 34 гарцаашийн газрыг албадан чөлөөлөх ажлыг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулан ажилласан. Үлдсэн 10 байршлын 134 гарцаашийн газрын зөрчил арилгах календарьчилсан төлөвлөгөөний дагуу чөлөөлөхөөр төлөвлөн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30
----	---	---	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ГУРАВ: Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа өнгө үзэмжгүй хашаа, хайс, эвдэрч гэмтсэн шон, самбаруудыг буулган цэгцлэх, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх ажлуудыг газар дээр хяналт тавьж, зөрчлийг арилгуулах ажлаа эрчимжүүлэх.

3.	- Дүүргийн хэмжээнд хашаа хайс угаах, эвдэрсэн хашаа хайсыг засварлах ажил эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 60м2 засварлаад байна. Дүүргийн гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ хариуцсан “Соёндрийм” ХХК нь 2022 оны 03 дугаар сарын 22-ны 17 дугаар хорооны авто замд тээврийн хэрэгсэл мөргөж дахин ашиглахгүй болсон гэрэлтүүлгийн шонг шинэчлэн засварласан. - Гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ хариуцсан “Соёндрийм” ХХК тэй хамтран 1-6, 7-19 дүгээр хороодын гэрэлтүүлгийн үзлэг шалгалтыг хуваарийн дагуу сард 2 удаа хийж 7, 9, 13, 14, 15 дугаар хороонд далийсан 5 гэрэлтүүлгийн шонг засварласан. - Дүүргийн төвийн 1-6 дугаар хороодод өнгө үзэмжгүй хашаа, хайсны судалгааг 2022 оны байдлаар шинэчлэн гаргахаар ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
----	---	---	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Монгол Улсын Их Хурлаас батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулагдах Нийслэл “RISE-Academy” арга хэмжээнд нийслэлийн Удирдах албан тушаалтнууд бүгд оролцох.

4.	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, JCI Монгол хамтран “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Нийслэл “ROCE-Academy” сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулах сургалтын хөтөлбөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 03/1288 тоот албан бичгээр ирсний дагуу дүүргийн Засаг дарга биечлэн оролцно.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
----	---	---	---------------------------------------	----

Үүрэг, даалгавар ТАВ: Монгол эдийн засгийн форум-2022” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-ын арга хэмжээ 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдах тул нийслэлийн Удирдах албан тушаалтнууд бүгд оролцох.

5.	Монгол эдийн засгийн форум-2022" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын арга хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр дүүргийн Засаг дарга биечлэн оролцоно.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Алхацаа гүйцгээ" хөдөлгөөнийг өрнүүлж 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сар хүртэл тогтмол зохион байгуулж, иргэдийг идэвхтэй хамруулах.				
6.	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 3/537 дугаар албан бичгээр "Оролцоог ханган ажиллах тухай" дүүргийн хороодын Засаг дарга наст, 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 3/548 дугаар албан бичгээр "Хэрэгжилтийг ханган ажиллах тухай" дүүргийн Биеийн тамир, спортын хороонд тус тус чиглэл хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
Үүрэг, даалгавар ДОЛОО: Нийслэлийн иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргүүдийн нутаг дэвсгэрт байгаа нийтийн биеийн тамирын талбай, ногоон байгууламж, гүйлтийн зам талбай болон бусад иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх талбайн бүртгэл судалгааг гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.				
7.	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа нийтийн биеийн тамирын талбай, ногоон байгууламж, гүйлтийн зам талбай болон бусад иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх 45 талбайн судалгааг нэгтгэн гаргаж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50
Үүрэг, даалгавар НАЙМ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт байгаа ногоон байгууламжуудаа нэмэгдүүлэх чиглэлээр ажлаа эрчимжүүлж ажиллах.				
8.	Дүүргийн төсвийн хөрөнгөөр болон урсгал зардлын хөрөнгөөр 2 дугаар улиралд хийгдэх ногоон байгууламжийн төлөвлөгөөг гаргасан бөгөөд "Тэрбум мод" аяны хүрээнд 5000 мод дээд салхитын аманд тарих, Тахилтын аманд 4 тэрбум төгрөгийн өртөгтэй цэцэрлэгт хүрээлэнгийн ажил хийгдэхээр төлөвлөн зураг төсвийн ажил хийгдэж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ХАНГАЙ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМАА